



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 625

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 330,000,000.00 (гурван зуун гучин сая) төгрөгийн балансын үнэ, 186,464,856.54 (нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга найман зуун тавин зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл“Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газар захирал С.Энхбаяр, Эрчим хүчний хөгжлийн төвийн төрийн захирал А.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001267

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨРӨНГИЙН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТ ИЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 1-дугаар сарын 31-ны өдрийн
688 дугаар тогтоолын хавсралт

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашигталтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэх хуулийн этгээд	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Лексус LX570, 00-73 УНУ, УТНУТАХ7D4100680	2012/2012	180,000,000.00	139,500,000.00	40,500,000.00	Засгий газрын автобааз УТӨӨТҮГ	Эрчим хүчний хөгжлийн төв
2	Ланд крузер LC-200 GXR, 44-03 УБЗ, УТМНУ0J3J4153559	2017/2017	150,000,000.00	46,964,856.54	103,035,143.46	Эрчим хүчний хөгжлийн төв	Засгий газрын автобааз УТӨӨТҮГ
Нийт дүн			330,000,000.00 (Гурван зуун гучин сая)	186,464,856.54 (нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга найман зуун тавин зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө)	143,535,143.46 (нэг зуун дөчин гурван сая таван зуун гучин таван мянга нэг зуун дөчин гурван төгрөг дөчин зургаан мөнгө)		